




**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

***“Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны
үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайлан***



***Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгож
байгаа хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт
хангалтгүй байна.***

Баянхонгор сум
2016 он

АГҮҮЛГА

Тайланг бэлтгэсэн:

Үндэсний Аудитын газрын
харьяа Баянхонгор аймгийн
Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор

Ё. Сугаррагчаа

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Ахлах аудитор А. Цэням

Аудитор Б.Должмаа

П.Мөнх-Эрдэнэ

2016 оны 10 дугаар сарын 05

Тайланг:

Аймгийн аудитын газрын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар

нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70442584, 70442424 дугаарын
утсаар харилцана уу.

ХАЯГ: Үндэсний аудитын
газрын харьяа

Баянхонгор аймгийн

Аудитын газар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ..... 1

Бүлэг-1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих
сангийн үйл ажиллагааны үр дүн.

АУДИТЫН ТАЙЛАН
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур
үзүүлэлт, аудит хийх үндэслэл.....2

АУДИТЫН ДҮН..... 4

Зорилт 1: Хувийн хэвшлийн “Өлзийт” ХАА-н МСҮТ-д
суралцаж байгаа 320 суралцагчийн 80 гаруй хувь нь
ерөнхий боловсролын сургуульд давхар суралцаж
байгааг шийдвэрлэх хууль зүйн зохицуулалт байхгүй
байна. 4

Зорилт 3: Аймгийн хэмжээнд жил бүр дунджаар 864
хүүхэд 20 мэргэжлээр мэргэжлийн боловсрол,
мэргэжлийн сургалт эзэмшсэн, тэдгээрийн 62,4% нь
ажил эрхэлж байгаагаас харахад Мэргэжлийн
боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлсэн
санхүүжилт үр дүнгээ өгсөн байна. 5

Зорилт 4: Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих
сангаас олгож байгаа хөрөнгийн зарцуулалтад тавих
дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж чадахгүй байна.
12

ҮАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ 14

АУДИТЫН ДҮГНЭЛТ 15

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ 16

ХАВСРАЛТ МАЯГТ 17-40

БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ 41-44

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ 45-46

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	-ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НАГ	-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР
НА	-НИЙЦЛИЙН АУДИТ
УИХ	-УЛСЫН ИХ ХУРАЛ
ИТХ	- ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	- ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
МБСДС	- МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САН
МСҮТ	- МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ
БСШУЯ	- БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МБС	- МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТ
ХАА	- ХӨДӨӨ АЖ АХУЙ
ЕБС	- ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны "Аудитын сэдэв батлах тухай" 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

2. Аудитын зорилт:

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон "Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан"-гийн үйл ажиллагаа, тус сангаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Хууль, эрх зүйн зохицуулалт нь сангийн үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх.
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх.
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх.
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг батлагдсан төлөвлөгөөний дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас Баянхонгор аймаг дахь Политехник коллеж, "“Өлзийт”" ХАА-н МСҮТ-дэд олгосон хувьсах зардал, суралцагчдын тэтгэлгийн зарцуулалтыг 2015 он, 2016 оны эхний 8 сарын байдлаар хамруулан шалгав.

4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, нийцлийн аудитын гарын авлага Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000-4200-г баримтлан, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга хийх, судалгаа гаргуулах, дүн, шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актууд болон шаардлагатай бусад баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

Төрийн аудитын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, Засгийн газрын 2007 оны 294, 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”, Засгийн газрын 1998 оны 188 –р тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам”, 2012 оны 189-р тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт”, Засгийн газрын 2012 оны 94-р тогтоолын 4-р хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”, Засгийн газрын 2013 оны 329-р тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох тухай” болон холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журмыг ашиглав.

Үндсэн мэдээлэл:

Баянхонгор аймагт Байгаль орчныг хамгаалах сан, Сургалтын төрийн сан, Зэвсэгт хүчний хөгжлийн сангууд байхгүй байна.

Харин Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас төрийн өмчит Политехник коллежид олгосон суралцагчдын тэтгэлэг, хувийн ““Өлзийт”” ХАА-н МСҮТ-д олгосон хувьсах зардал, тэтгэлгийн зардал тус аудитад хамрагдав.

А.Политехник коллеж:

Баянхонгор болон хил залгаа аймгуудыг барилгын мэргэжилтэй ажилчдаар хангах зорилгоор 1963 онд “Барилгын сургууль комбинат” нэртэй анх байгуулагдсан, 1990 оноос МСҮТ болон өргөжиж, магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/24 тоот тушаалаар Политехник коллежийн ангилалд шилжүүлэн тусгай зөвшөөрөл олгож, барилгын техникч, барилга угсралтын техникч, цахилгааны техникч, аюулгүй ажиллагааны мэргэжлээр сургалт явуулахыг зөвшөөрсөн байна.

Политехник коллежид 2014-2015 оны хичээлийн жилд 1163, 2015-2016 оны хичээлийн жилд 1109, 2016-2017 оны хичээлийн жилд 2016 оны 9 дүгээр сарын 22 –ны байдлаар 1049 хүүхэд хамрагдан суралцаж байна.

Санхүү, хөрөнгийг захиран зарцуулахдаа 1-р гарын үсгийг сургуулийн захирал Ш.Чимгээ, 2-р гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Ц.Цэвээнсүрэн нар зурсан байна.

Б. "Өлзийт" Хөдөө аж ахуйн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв /цаашид "Өлзийт" ХАА-н МСҮТ" гэх/

БСШУЯ-ны сайдын 2006 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 308 тоот тушаалаар Баянхонгор аймагт хувийн хэвшлийн "Өлзийт" ХАА-н МСҮТ нь техник, тусгай мэргэжлийн дунд боловсрол олгох үйл ажиллагаа эрхлэхээр үүсгэн байгуулагдсан бөгөөд жил бүр 320 суралцагч суралцаж, захиргаа аж ахуйн ажилтан 6, багш 7, номын санч 1, үйлчилгээний ажилтан 7, нийт 21 орон тоогоор ажиллаж байна. Тус сургууль нь суралцагчдаас сургалтын төлбөр авдаггүй.

Сургуулийн санхүү, хөрөнгийг захиран зарцуулахдаа зөвхөн санхүүгийн албаны дарга Г.Сүрмаа 1-р гарын үсгийг зурж гүйлгээ хийж байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

А. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САН

Зорилт 1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хууль эрх зүйн зохицуулалт оновчтой байна.

1.1 Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.24-т "Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан" /цаашид МБСДС гэх / байхаар, хуулийн 6.1.1-т уг санг тусгай хуулиар зохицуулахаар заажээ. "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" хуулийн 21.1¹-т заасны дагуу уг сангийн удирдлагын үүргийг Хөдөлмөрийн сайд эрхлэх бөгөөд сангийн хөрөнгийн зарцуулалтад боловсрол, санхүү, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл хяналт тавин ажиллаж байна.

Дээрх хуулийн 21.2-т "Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална" гэж заасны дагуу 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байгуулагдаж Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор "Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг баталсанаар сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрджээ.

¹ "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" хуулийн 21.1 дэх хэсэгт "Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ"

1.2 Батлагдсан хууль, дүрэм, журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.2² -т зааснаар санхүүжилтийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлыг Засгийн газрын 2012 оны 94 тоот тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-аар, суралцагчдад олгох тэтгэлгийг Засгийн газрын 2007 оны 94, 2015 оны 477 тоот тогтоолуудаар батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын дагуу олгож, сангийн үйл ажиллагааг зохицуулж ирсэн байна.

1.3. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм журмууд нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байгуулагдаж, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам батлагдсан нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

Зорилт 2. “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн 21.1-т заасны дагуу МБСДС-гийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх тул аудитын 2 дугаар бүлгийн зорилт орон нутагт хамаарахгүй болно.

Зорилт 3. Аймгийн хэмжээнд жил бүр дундажаар 864 хүүхэд 20 мэргэжлээр мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалт эзэмшиж төгссөнөөс, 62,4% нь ажил эрхэлж байгаагаас харахад Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлсэн санхүүжилт үр дүнгээ өгсөн байна.

3.1 МБСДС-гаас санхүүжүүлсэн хувьсах зардал, суралцагчдын тэтгэлгийн санхүүжилт нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа ч “Өлзийт” ХАА-н МСҮТ нь 2016 оны 1, 2-р сард хичээллээгүй атлаа суралцагчийн ирцийн мэдээллийг 3, 4-р сарын мэдээгээр өгсөн нь Тэтгэлэг олгох журмын 3.2 дахь заалтыг зөрчсөн байна.

² “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.2-т “өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэгт сангийн хөрөнгийг зарцуулах”-

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.2³-т заасны дагуу МБСДС-гаас Баянхонгор аймагт 2015-2016 онд суралцагчийн тэтгэлэгт 945,7 сая төгрөг олгохоос 731,9 сая төгрөг олгож, 213,8 сая төгрөг дутуу олгосон, “Өлзийт” ХАА-н МСҮТ-ийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын санхүүжилтэд 2016 оны 8-р сарын 30-ны байдлаар 310418,9 мянган төгрөг олгохоос бүрэн олгосон байна. /Хавсралт маягт №1, 8 /

А. Суралцагчийн тэтгэлэг: Политехник коллеж 2015-2016 оны хичээлийн жилд нийт 1109 суралцагчтай, үүнээс 2.5 жилийн мэргэжлийн боловсролд 274, нэг жилийн мэргэжлийн сургалтад 235 суралцагч, нийт шинээр 509 суралцагч элсэж, барилга, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын 20 мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 1.2⁴ дэх заалтын дагуу Политехник коллеж 2015-2016 оны хичээлийн жилд суралцсан 1109 суралцагчаас 24-өөс дээш насны 30, цэргийн 38 албан хаагчдад тэтгэлэг олгоогүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 320 дугаар тогтоолын 4-т цэргийн алба хааж байгаа иргэдэд зохих түвшний мэргэжлийн чадамж эзэмшүүлэн гэрчилгээ олгох, тэднийг ажлын байранд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлэх гэсэн заалтын дагуу тус аймаг дахь Зэвсэгт хүчний 339-р ангитай “Эрэлт, сургалт, ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулан, 2015-2016 оны хичээлийн жилд 38 албан хаагчийг сургасан байна.

Д/Д	Үзүүлэлт	2014 оны 9-р сард	2015 оны 1-р сард	2015 оны 6 сард	2015 оны 9 сард	2016 оны 1 сард	2016 оны 6 сард
1	Нийт суралцагч	1163	845	600	1109	800	565
2	Мэргэжлийн боловсрол	918	600	600	874	565	565
3	Үүнээс Мэргэжлийн сургалт 1 жилтэй 1-р анги	291	291	291	274	274	274
4		309	309	309	291	291	291
5		318			309		
6	Мэргэжлийн сургалт 1 жилтэй 1-р анги	245	245	0	235	235	0
7	Нийт суралцагчаас 24 -ээс дээш насны суралцагч	74	74	74	30	30	30
8	Гэрээний дагуу цэргийн алба хааж байх хугацаанд суралцагч	40	40		38	38	
9	Нийт тэтгэлэгт хамрагдах суралцагчийн тоо	1049	731	526	1041	732	535

“Өлзийт” ХАА-н МСҮТ-д хүнсний ногооны фермер, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологийн ажилтан, ойжуулагч мэргэжлээр жил бүр 320 суралцагч суралцаж байна.

³ “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.2 дэх хэсэгт “өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэгт сангийн хөрөнгийг зарцуулах”

⁴ Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 1.2-т “Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2,5 жил, техникийн боловсролын 1,5 болон 3 жилийн сургалтанд хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчид тэтгэлэг олгоно”

Хувийн хэвшлийн “Өлзийт” ХАА-н МСҮТ-д суралцаж төгссөн суралцагчдыг 3 оноор нь харьцуулж үзэхэд 71 суралцагч 2 жил дараалан, 1 суралцагч 3 жил дараалан, Политехник коллежид 13 суралцагч 2 жил дараалан суралцсан байхад суралцагчдад тэтгэлэг олгосон нь Засгийн газрын 2007 оны 294-р тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 2-т “Тэтгэлгийг мэргэжлийн боловсролыг анх удаа эзэмшиж байгаа суралцагчдад олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна. Харин 2015 оны 477 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-д дээрх заалт тусгагдаагүй байна.

Баянхонгор аймгийн Политехник коллеж, “Өлзийт” ХАА-н МСҮТ нь 2015 он, 2016 оны эхний 8 сарын байдлаар суралцагчдын тэтгэлгийг олгохдоо суралцагчдын хичээлийн ирцийн бүртгэлийг анги удирдсан багш батлагдсан маягтын дагуу суралцагчдын цагийн тооцоог нэгтгэн гаргаж, сургалтын албаны дарга, нягтлан бодогч нар хянаж, дэд захирлаар батлуулан суралцагчдад олгох тэтгэлгийг тооцож, Хөдөлмөрийн яаманд хүргүүлсэн байна.

МБСДС-гаас 2015 оны 9 дүгээр сар хүртэлх суралцагчдын тэтгэлгийн санхүүжилтийг сургуулийн харилцах дансанд олгосныг тухай бүрд нь арилжааны банкин дахь сурагцагчдын тэтгэлгийн нэрийн дансанд шилжүүлжээ.

Харин 2015 оны 10 дугаар сараас хойшхи хугацааны суралцагчдад олгох тэтгэлгийн тооцоог Хөдөлмөрийн яаманд хүргүүлснээр Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгох тухай журам”-ын дагуу тэтгэлгийг МБСДС-гаас суралцагчийн картын дансанд шууд шилжүүлсэн байна. Тус аймгийн суралцагсдад Капитал банкин дахь суралцагчдын нэрийн дансаар дамжуулан тэтгэлгийг шилжүүлэн олгожээ. Сургуулиуд нь суралцагчдын тэтгэлгийг олгохдоо 2015 онд суралцагчдын хичээл тасалсан цагийг хасч тооцож олгосон ба 2016 оны 01 дүгээр сараас эхлэн Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 2.2.2-т “хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтанд 75%-иас доошгүй ирцтэй оролцсон байх” гэсэн шаардлагын дагуу тооцжээ.

Аймгийн сургуулиудын хэмжээнд 2015 онд суралцагчдын тэтгэлэгт нийт 649190,1 мянган төгрөг олгохоос 407288,0 мянган төгрөгийг олгож, 2015 оны 10-12 саруудын тэтгэлгийн 241902,1 мянган төгрөгийг дутуу олгожээ. /Хавсралт маягт №4/ Уг олгогдоогүй тэтгэлгийг 2016 оны 4, 5, 6 дугаар саруудад олгосон бөгөөд 2016 оны 1-6 сард 296506,4 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоос 82698,2 мянган төгрөгийг олгож, **213808,2** мянган төгрөгийн тэтгэлгийг МБСДС-гаас олгоогүй байгаа нь

Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 3.3⁵- дахь заалт зөрчигдөж байна./Хавсралт маягт №5/

Тэтгэлгийн тооцоог сургууль, он тус бүрээр харуулбал:

Д/д	Сургуулийн нэр	2015 он				2016 он				2016.08.31-ний байдлаар дутуу олгосон тэтгэлгийн дүн /мян.төг/
		Суралцагчийн тоо	Олговол зохих тэтгэлгийн дүн /мян.төг/	Олгосон тэтгэлгийн дүн /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Суралцагчийн тоо	Олговол зохих тэтгэлгийн дүн /мян.төг/	Олгосон тэтгэлгийн дүн /мян.төг/	Зөрүү /мян.төг/	
1	Политехник коллеж	946	447,283.10	266,264.20	181,018.90	624	175,099.40	222,649.30	-47,549.90	133,469.00
2	Өлзийт ХАА-н МСҮТ	320	201907.00	141023.80	60,883.20	320	121407.00	101951.00	19,456.00	80,339.20
Дүн		1266	649,190.10	407,288.00	241902.10	944	296,506.40	324,600.30	-28,093.90	213,808.20

Дээрх судалгаанаас харахад 2016 оны 3-6-р сарын тэтгэлгийн 213,8 сая төгрөгийг МБСДС-гаас олгоогүй байгаа нь Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 3.3⁶- дахь заалт зөрчигдөж байна.

Аудитын явцад Политехник коллежийн багшийн сурагчдын ирцийн бүртгэлийг нягтлан бодогчийн олгохоор тооцсон жагсаалттай тулган шалгахад 2015 оны 1-3 сард багш нар цагийн нэгтгэл хийхдээ суралцагчдийн сар бүрийн цагийн ирцийн тооцооноос 27 хүүхдэд 534,2 мянган төгрөгийг илүү тооцсоноос суралцагчдад тэтгэлгийг илүү олгосон зөрчил илэрч, холбогдох албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов. Харин “Өлзийт” ХАА-н МСҮТ нь Мэргэжлийн боловсролын сургалтын бодлого зохицуулалтын газраас баталсан сургалтын төлөвлөгөөг үндэслэн хичээлийн жилийн хуваарийг гаргахдаа тухайн оны 1, 2-р саруудад амарч, 7, 8-р саруудад үйлдвэрлэлийн дадлага хийхээр баталдаг байна. 2015 оны 1, 2-р сарын санхүүжилтийг урьдчилан 3 дугаар сард сангаас сургуулийн дансанд олгосныг 7, 8-р сарын суралцагчийн ирцийн мэдээнд үндэслэн олгосон байна. Харин 2016 оны 1, 2-р сарын мэдээг 2016 оны 3, 4-р сарын гүйцэтгэлээр 05 дугаар сард нөхөн мэдээлж, тэтгэлэг олгогдсон байгаа нь “Тэтгэлэг олгох журам”-ын 3.2⁷- дахь заалтыг зөрчжээ. Энэ талаар нягтлан бодогчоос тодруулахад “Хөдөлмөрийн яамны Санхүү, эдийн засгийн газрын мэргэжилтэн Д.Гантуяа 1, 2-р сарын мэдээг өгөөгүй шалтгааныг надаас тодруулсан, би тайлбар өгч 7,8-р сард хичээллэнэ гэсэн гэтэл мэдээг урьдчилан ямар нэгэн байдлаар өгөөгүй тохиолдолд санхүүжилт олгохгүй гэсэн” учраас би мэдээг урьдчилан хүргүүлсэн гэсэн тайлбарыг өгөв.

⁵ Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 3.3-т “Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сар бүр ирцийн мэдээллийг хянан магадласаны үндсэн дээр тэтгэлгийг суралцагчийн дансанд сар бүр шилжүүлнэ”

⁶ Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох журам”-ын 3.3-т “Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сар бүр ирцийн мэдээллийг хянан магадласаны үндсэн дээр тэтгэлгийг суралцагчийн дансанд сар бүр шилжүүлнэ”

⁷ “Тэтгэлэг олгох журам”-ын 3.2-т “Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын ирцийн мэдээллийг энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу тооцон нэгтгэж, дараа сарын 05-ны өдрийн дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”

Ийм учраас цаашид суралцагчийн ирцийн мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь гаргаж байх зөвлөмжийг “Өлзийт” ХАА-н МСҮТ-д хүргүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газраас баталсан нэг жилийн мэргэжлийн чадамжид суурилсан төлөвлөгөөгөөр суралцах хугацааг 10 сараар тогтоож, мэргэжил тус бүрээр баталсан боловч хичээллэх хугацааны графикийг сар бүрээр нарийвчлан батлаагүйгээс сургуулиуд харилцан адилгүй хугацаанд хичээллэж, тэтгэлгийг хувийн хэвшлийн МСҮТ нь 10 сараар олгосон байхад төрийн өмчийн сургууль 9 сараар олгосон байна. Энэ нь хичээлийн жилийн сургалтын явцын хуваарийг Политехник коллеж нь суралцсан хугацаанд 3 долоо хоног амарч, тухайн хугацаанд суралцагчдад тэтгэлэг олгоогүй байна.

“Өлзийт” ХАА-н МСҮТ-д ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид давхар суралцаж байгаагаас өглөө 8.00-12.20 цаг, өдөр 14.00-18.20 цаг хүртэл 2 ээлжээр хичээллэж, тухайн оны 1, 2-р сард амарч суралцагчдад тэтгэлэг олгоогүй, харин 7, 8-р сард үйлдвэрлэлийн дадлага хийдэгтэй холбоотойгоор ирцийн мэдээллийг үндэслэн тэтгэлгийг олгож, нийт тэтгэлэгийг 10 сараар олгосон байна. Иймд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газраас баталж байгаа сургалтын төлөвлөгөөг хичээлийн жилээр эхлэх, дуусах хугацаа, амрах хоногоор нь нарийвчлан гаргаж, сургуулиудад нэгэн адил мөрдүүлэх саналыг ҮАГ-т уламжлав.

“Өлзийт” ХАА-н МСҮТ-ийн 2015 оны санхүүгийн тайлангаар 3565,3 мянган төгрөгийн санхүүжилт, тэтгэлгийн өглөгтэй гарсаныг аудитаар тодруулан шалгахад 2014 онд тэтгэлгийн санхүүжилтэнд 217576,4 мянган төгрөг авч, суралцагчдын тэтгэлэгт 214210,3 мянган төгрөгийг олгож, суралцагчийн хичээлийн ирцийн зөрүүнээс 3366,1 мянган төгрөгийг олгоогүй атлаа санд буцаан төвлөрүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2007 оны 294-р тогтоолоор батлагдсан “МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ын 9-т “Суралцаж байгаа хүний тооноос хамааран санхүүжилтийг хэмжээнд өөрчлөлт орсон... тохиолдолд зөрүүг төсөвт буцаан төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн тул МБСДС-д буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Б. Хувьсах зардал: Хувийн хэвшлийн “Өлзийт” ХАА-н МСҮТ-д суралцаж байгаа 320 суралцагчийн 80 гаруй хувь нь ерөнхий боловсролын сургуульд давхар суралцаж байгааг шийдвэрлэх хууль зүйн зохицуулалт байхгүй байна.

Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолоор мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Баянхонгор аймагт 610,1 мянган төгрөгөөр тогтоосон.

Дээрх тогтоолын дагуу МБСДС-гаас “Өлзийт” ХАА-н МСҮТ-ийн 320 суралцагчийн хувьсах зардалд 2015 онд 195232,0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоос, гүйцэтгэлээр 152998,4 мянган төгрөгийг олгож, оны эцэст **42233,6** мянган төгрөгийн санхүүжилтийн авлагатай гарчээ. /Хавсралт маягт №2/ 2016 оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны санхүүжилтийн дутуу 42233,6 мянга, тайлант хугацааны суралцагчдын хувьсах зардлын 115186,9 мянга, нийт 157420,5 мянган төгрөгийг олгож, **өглөг, авлагагүй** гарсан байна./Хавсралт маягт №3/

“Өлзийт” ХАА-н МСҮТ-д 2014-2015 оны хичээлийн жилд 261, 2015-2016 оны хичээлийн жилд 263 хүүхэд буюу нийт суралцагчийн 80 гаруй хувь нь ерөнхий боловсролын сургуульд давхар суралцсан байна. Энэ талаар зохицуулсан ямар нэгэн хууль эрхийн акт байхгүйгээс нэг хүүхдэд ногдох хувьсах зардал ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-д давхардсан байна. Иймд цаашид төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч, судлан журамд өөрчлөлт оруулах эсэх талаар ҮАГ-ын хэмжээнд санал боловсруулж холбогдох байгууллагад тавих нь зүйтэй гэж үзэж саналыг хүргүүлэв.

Тус сургууль дээрх санхүүжилтийн орлогоос гадна өөрсдийн материаллаг бааз дээр тулгуурлан тариалсан хүнсний ногоо, чацаргана, цагаан идээний орлогоос 2015 онд 5298,1 мянга, 2016 оны эхний 8 сарын байдлаар 4877,5 мянган төгрөгийн, арилжааны банкинд байршиж буй дансны үлдэгдлийн хүүгийн орлогоос 2015 онд 1898,7 мянга, 2016 оны эхний 8 сарын байдлаар 1069,4 мянган төгрөгийн орлого оруулсаныг харилцах дансандаа төвлөрүүлсэн байна.

Зардлын гүйцэтгэлийг дэлгэрэнгүй харуулбал: /мян.төг/					
№	Төрөл, зүйл	2015 он		2016 оны эхний 8 сарын байдлаар	
		Мөнгөн дүн	Хувийн жин	Мөнгөн дүн	Хувийн жин
1	МБСДС-гаас олгох хувьсан зардал	152998.4	78%	157420.5	96%
2	Байгууллагын өөрийн орлого	7196.8	4%	5946.9	4%
3	Өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлсэн	37015.6	19%	0	0%
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		197210.8	100%	163367.4	100%
1	Цалин, шимтгэлийн зардал	119498.7	61%	70759.3	43%
2	Тогтмол зардал	19360.8	10%	7378.4	5%
3	Тээвэр шатахууны зардал	5513.2	3%	4234.4	3%
4	Хичээл практикийн зардал	19757.9	10%	15751.6	10%
5	Урсгал зардал	16458.6	8%	5564.4	3%
6	Бусад зардал	16621.6	8%	59679.3	37%
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		197210.8	100%	163367.4	100%

Аудитаар хувьсах зардлын зарцуулалтыг зардлын төрлөөр авч үзэхэд нийт зардлын 43-61 хувийг ажиллагсдын цалин, шимтгэлийн зардалд, 10 хувийг хичээл практикийн зардал зарцуулсан байна. Аудитаар “Өлзийт” ХАА-н МСҮТ-ийн ажиллагсдын цалин, хөлсний тооцоог тулган шалгахад 2016 оны 07 дугаар сард Т.Мөнхзулын цалинг буруу бодож 50675 төгрөгийн цалинг дутуу олгосон, 2015 онд кассаас 93,0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7⁸ гэсэн заалтыг зөрчсөн, хувьсах зардлын санхүүжилтээс 236,1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор батлагдсан “МБСДС-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.1⁹ дэх заалтыг зөрчсөн тул нийт 379,7 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтан, байгууллагаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.2, 3.3. МБСДС-гаас орон нутгийн сургалтын байгууллагад олгогдсон суралцагсадын тэтгэлэг олгох банкныг сонгон шалгаруулах тендерийг Хөдөлмөрийн яаманд зарласан, орон нутагт төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна.

3.4 Хичээлийн жилд батлагдсан хяналтын тооны 96,4 хувиар элсэлт авч мэргэжлийн боловсрол олгосон, нийт төгсөгчдийн 62,4 хувь нь ажил эрхэлж байгаагаас үзэхэд МБСДС-гаас зарцуулсан хөрөнгө үр дүнгээ өгч байна.

Баянхонгор аймаг дахь Политехник коллеж нь жил бүр элсэлтийн хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, орон нутгийн хэрэгцээ, захиалга, сургуулийн хүчин чадал, багш нарын ур чадвар, дадлагын бааз, сургалтын орчны бүрдэл зэргийг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснээр Хөдөлмөрийн сайдын 2015.07.06-ний өдрийн А/130 тоот тушаалаар 2015-2016 оны хичээлийн жилд элсүүлэх суралцагчдын хяналтын тоо батлагдаж, түүний дагуу элсэлтээ авчээ.

№	Үзүүлэлт	Баянхонгор аймаг дахь Политехник коллеж				Өлзийт ХАА-н МСҮТ			
		Элсэлтийн санал	хяналтын тоо	элсэлт	зөрүү	элсэлтийн санал	хяналтын тоо	элсэлт	зөрүү
1	Мэргэжлийн боловсрол олгох 2.5 жилтэй	265	285	274	11	-	-	-	0
2	Мэргэжлийн сургалт 1 жилтэй	270	255	235	20	320	320	320	0
Нийт дүн		535	540	509	31	320	320	320	0

Хувийн өмчит “Өлзийт” ХАА-н МСҮТ-д суралцах суралцагчийн хяналтын тоог 320-иор баталж, тэдгээрт ногдох хувьсах зардал, суралцагчдын тэтгэлгийг

⁸ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7-т “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно”

⁹ Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор батлагдсан “МБСДС-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.1-т “Сангийн хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23-р зүйлд зааснаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна”

Засгийн газраас тогтоосон нормативын дагуу төлөвлөж, гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгосон байна.

2015-2016 оны хичээлийн жилд тус аймагт элсэлтийн хяналтын тоо 860 хүнээр батлагдсанаас 96,4 хувиар буюу 829 суралцагч шинээр элсэн орсон бөгөөд сүүлийн 4 жилийн байдлаар нийт төгсөгчдийн дунд хийсэн мөшгөх судалгаанаас харахад тэдгээрийн 62,4 хувь нь ажил эрхэлж байгаагаас 69,3 хувь нь мэргэжлээрээ ажилласан байна.

Мэргэжлийн боловсролын суралцагчдад тэтгэлэг олгодог болсноор суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд хөшүүрэг болсон, иргэд мэргэжил эзэмших, түүгээрээ бизнес эрхлэх хүсэл сонирхол нэмэгдсэн гэсэн тайлбарыг сургуулийн захирал болон холбогдох албан тушаалтан өгсөн, мөн суралцагчдын хичээлийн ирц дунджаар 89,9%-тай байгаагаас үзвэл тус сангаас олгож буй тэтгэлэг зорилтот бүлэгтээ хүрч, үр дүнгээ өгч байна.

“Өлзийт” ХАА-н МСҮТ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн сургалт олгосноор суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагыг өөрийн сургуулийн эзэмшлийн талбайд явуулснаар туслах аж ахуйгаас чацаргана, үхрийн нүд, хүнсний болон нарийн ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүний орлогоос жилд 5,0 сая гаруй төгрөг оруулсан байна.

МБСДС-гийн хөрөнгөөр аймгийн Политехник коллежид мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхээр “Кареермарт” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 14,5 сая төгрөгийн өртөг бүхий “e-TVET” мэдээллийн программыг 2015 оны 03 дугаар сард ашиглалтад оруулжээ.

Уг мэдээллийн системд Политехник коллеж нь 2015-2016 оны хичээлийн жилийн багш, ажилчид, оюутан сурагчдын бүртгэлийг бүрэн оруулж бүртгэсэн, суралцагчдын явцын болон шалгалтын дүнг улирал, жилээр оруулж, анги, мэргэжил нас хүйс зэрэг олон хэлбэрээр тайлан гаргах, харах боломжтой, цаашид багш ажилчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, байгууллагад цаасгүй менежментийг нэвтрүүлэх, хөрөнгө, цаг хугацаа хэмнэх, чанар үр ашгийг сайжруулах олон талын ач холбогдолтой ажил болсон хэдий ч одоогоор программын зарим цэс бүрэн ашиглагдаагүй, засвар өөрчлөлт хийгдэж байна.

Зорилт 4. Дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн ч аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллага мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд, Политехник коллежийн дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн сангаас олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгээгүй байна.

4.1 Дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4.3-т журмын хэрэгжилтэд мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл, Боловсрол, Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавихаар заасан байна. Мөн Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуулийн 26.1¹⁰-т мэргэжлийн боловсролын сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавихаар заасан зэргээс үзэхэд хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

4.2 МБСДС-гаас олгож байгаа суралцагсдын тэтгэлэг, хувьсах зардлын зарцуулалтанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуулийн 26.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Политехник коллеж, “Өлзийт” ХАА-н МСҮТ-д 2014-2016 онуудад хяналт шалгалт хийгээгүй тухайгаа албан бичгээр манай байгууллагад ирүүлсэн болно. Сургуулиуд суралцагчдын хичээлийн ирц, цагийн бүртгэл, тэтгэлгийн олголтын тооцоололд сургалтын албаны дарга, нягтлан бодогч нар хяналт тавьж байгаа боловч ирцийн мэдээллийг буруу гаргаж хүргүүлснээр зарим тэтгэлгийг илүү олгосон зөрчил аудитаар илэрсэн нь дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Политехник коллежийн захирлын 2013.09.02-ны өдрийн 54 тоот тушаалаар байгууллагын дотоод хяналт хариуцсан мэргэжилтнээр Э.Чулууныг томилсон ч 2015, 2016 оны эхний 8 саруудад суралцагчдад олгосон тэтгэлэгт дотоод хяналт хийгээгүй байна.

4.3 Политехникийн коллеж нь Шилэн дансны хуулийн 5.5.5-д заасан, 6.4.4-д заасан мэдээлэлийг шилэн дансны нэгдсэн цахим портал сайтад байршуулсан байна.

Политехник коллеж нь 2015 онд суралцагсдын тэтгэлэгт авсан 266.1 сая төгрөг, 2016 оны 43,8 сая төгрөгийн санхүүжилт, түүний зарцуулалтыг Шилэн дансны тухай хуулийн 5.5¹¹, 6.4.4¹²-т заасны дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn сайтад мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн

¹⁰ Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуулийн 26.1- т “мэргэжлийн боловсролын сургалтын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина”

¹¹ Шилэн дансны тухай хуулийн 5.5¹¹-дэхь хэсэг “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна

¹² Шилэн дансны тухай хуулийн 6.4.4¹² -т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”

мэдээлж, мөн байгууллагын ил тод мэдээллийн самбарт мэдээллийг байршуулсан байна.

“Өлзийт” ХАА-н МСҮТ нь шилэн дансны нэгдсэн портал сайтад цэсгүй ба байгууллагын мэдээллийн самбарт цаасаар тухай бүр мэдээллийг байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 6.9¹³-т заасны дагуу МБСДС-гаас олгосон суралцагчдын хувьсах зардал, тэтгэлгийн санхүүжилтийн мэдээллийг Хөдөлмөрийн яам шилэн дансанд мэдээлж байна.

Аудитаар нийт 4280,0 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч, байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхээр 3 төлбөрийн акт тогтоов.

ҮАГ-т хүргүүлэх санал:

1. Баянхонгор аймаг дахь хувийн хэвшлийн “Өлзийт” ХАА-н МСҮТ-д 2014-2015 оны хичээлийн жилд 261, 2015-2016 оны хичээлийн жилд 263 хүүхэд буюу нийт суралцагчийн 80 гаруй хувь нь ерөнхий боловсролын сургуульд давхар суралцаж байгааг зөвшөөрсөн, хориглосон хууль эрхийн акт байхгүйгээс нэг хүүхдэд ногдох хувьсах зардал ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-д давхардсан байна. Энэ асуудлыг судлан, холбогдох журамд өөрчлөлт оруулах эсэх талаар ҮАГ-ын хэмжээнд санал боловсруулж, холбогдох байгууллагад тавих.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газраас баталсан нэг жилийн мэргэжлийн чадамжид суурилсан сургалтын төлөвлөгөөгөөр суралцах хугацааг 10 сараар тогтоож, мэргэжил тус бүрээр баталсан боловч хичээллэх хугацааны графикийг батлаагүйгээс сургуулиуд харилцан адилгүй хугацаанд хичээллэж, тэтгэлгийг хувийн хэвшлийн МСҮТ нь 10 сараар олгосон байхад төрийн өмчийн сургууль 9 сараар олгосон байна. Энэ нь хичээлийн жилийн сургалтын явцын хуваарийг Политехник коллеж нь суралцсан хугацаанд 3 долоо хоног амрахаар, тухайн хугацаанд суралцагчдад тэтгэлэг олгоогүй байхад хувийн хэвшлийн “Өлзийт” ХАА-н МСҮТ 10 сараар хичээллэхээр хичээлийн хуваарийг гаргаж, тэтгэлгийг 10 сараар олгосон байна. Иймд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газраас баталж байгаа сургалтын төлөвлөгөөг хичээлийн жилээр эхлэх, дуусах хугацаа, амрах хоногоор нь нарийвчлан гаргаж, сургуулиудад нэгэн адил мөрдүүлэх.

¹³ Шилэн дансны тухай хуулийн 6.9¹³-т, - 6.9.10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан,, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно.

[Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн]

YAГ-НАГ/2016/03-НА/ БАГ-03

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.2-т заасны дагуу МБСДС-гаас Баянхонгор аймагт 2015-2016 онд 320 суралцагчийн хувьсах зардалд 310,4 сая төгрөгийг бүрэн олгож, 1266 суралцагчийн тэтгэлэгт 945,7 сая төгрөг олгохоос 731,9 сая төгрөг олгож, 213,8 сая төгрөг дутуу олгосон нь Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-ын 3.3 дахь заалтыг Хөдөлмөрийн яам зөрчжээ.

2. Аймгийн хэмжээнд жил бүр дунджаар 864 хүүхэд 20 мэргэжлээр мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалт эзэмшсэн, тэдгээрийн 62,4% нь ажил эрхэлж байгаагаас харахад Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлсэн санхүүжилт үр дүнгээ өгсөн байна.

3. Хувийн хэвшлийн "Өлзийт" ХАА-н МСҮТ-д суралцаж байгаа 320 суралцагчийн 80 гаруй хувь нь ерөнхий боловсролын сургуульд давхар суралцаж байгааг шийдвэрлэх хууль зүйн зохицуулалт байхгүй байна.

4. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд, Политехник коллежийн дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн сангаас олгосон суралцагчийн тэтгэлгийн олголтод хяналт шалгалт хийгээгүй нь дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

5. Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газраас баталсан сургалтын төлөвлөгөөг хичээлийн жилээр эхлэх, дуусах хугацаа, амрах хоногоор нь нарийвчлан гаргаагүйгээс сургуулиуд хичээлийн хуваарийг харилцан адилгүй хийснээс шалтгаалан төрийн өмчийн сургууль 9 сар, хувийн хэвшлийн сургууль 10 сараар тооцон суралцагчдад тэтгэлгийг олгожээ.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Е.СУГАРРАГЧАА

[Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн]

ҮАГ-НАГ/2016/03-НА/ БАГ-03

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2016.10.04

Баянхонгор сум

Аймгийн аудитын газар Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд нийцлийн аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорхи албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нэг. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Бямбадоржид

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26.1-т заасны дагуу тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Политехник коллеж, "Өлзийт" ХАА-н МСҮТ-ийн үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж ажиллах.

Хоёр. Политехник коллежийн захирал Ш.Чимгээд

1. Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-ын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлэн, суралцагчийн хичээлийн ирцийн мэдээлэл, олголтод тавих дотоод хяналтыг сайжруулах.

Гурав. "Өлзийт" ХАА-н МСҮТ-ийн захирал С.Бямбадорж, санхүүгийн албаны дарга Г.Сүрмаа нарт

1. Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-ын 3.2 дахь заалтыг зөрчин тайлант оны 1, 2-р сард хичээллээгүй байхад ирцийн мэдээллийг урьдчилан өгдөг байдлыг зогсоож, үнэн зөв, хугацаанд нь мэдээлж байх.

2. МБСДС-гаас олгож байгаа нэг суралцагчдад ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилтийг сургалтын үйл ажиллагаанд зарцуулж байх.

Нийцлийн аудитаар тогтоосон актыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2016 оны 11-р сарын 20-ны дотор аймгийн Аудитын газарт хариу ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Е.СУГАРРАГЧАА